26+258.740	762.624	763.286	0.662	-1	—
26+260.000	762.591	763.284	0.693	-1	—
26+270.334	762.330	763.268	0.938	-1	—
26+280.000	762.368	763.254	0.886	-1	—
26+285.407	762.413	763.246	0.833	-1	—
26+295.407	762.450	763.231	0.780	-1	—
26+299.698	762.468	763.224	0.756	-1	—
26+300.000	762.470	763.224	0.754	-1	—
26+320.000	762.363	763.194	0.831	-1	—


## ТАЙЛБАР БИЧИГ

26+340.000	762.231	763.164	0.932	-1	—
26+360.000	762.586	763.134	0.547	-1	—
26+380.000	762.343	763.104	0.761	-1	—
26+398.039	762.295	763.077	0.782	-1	—


### 3.3. Хөндлөн огтлол төсөллөлт

Замын хөндлөн огтлолыг авто замын стандартад заасан хэмжээнүүдийг ашиглаж төлөвлөсөн. Үүнд:


- Зорчих хэсгийн өргөн - 7.0м /эгнээний тоо – 2, нэг зурвасын өргөн – 3.5м, хэвгий 2%/
- Хөвөөний бэхэлгээ – 0.5м /зорчих хэсгийн 2 талд, хэвгий 2%/
- Хөвөө – 1.5м /зорчих хэсгийн 2 талд, хэвгий 2%/
- Ногоон байгууламж – 1.5м /зорчих хэсгийн баруун талаар, хэвгий 2%/
- Дугуйн зам – 2.5м /зорчих хэсгийн баруун талаар, хэвгий 2%/
- Хөвөө – 0.5м /зорчих хэсгийн баруун талаар, хэвгий 2%/
- Нийт далангийн өргөн – 15.5м
- Явган хүний зам – 3м / Авто машины зогсоол, автобусны буудал, түр зогсоол/




Зураг 5. Нэг маягийн хөндлөн огтлол 1-1 /Далантай үед/




Зураг 6. Нэг маягийн хөндлөн огтлол 2 – 2 /Ухмалтай үед KM4+200 ~ KM4+440/



Зураг 7. Нэг маягийн хөндлөн огтлол 3 - 3 /Шүүрүүлэх далантай үед KM24+000 ~ KM26+160/




Зураг 8. Нэг маягийн хөндлөн огтлол 4 - 4 /Давуулах далан/




Зураг 9. Нэг маягийн хөндлөн огтлол 5 – 5 /Ус залах далан/




# ТАЙЛБАР БИЧИГ



Зураг 10. Нэг маягийн хөндлөн огтлол 6 - 6 /Морь барианы 97ш авто машины зогсоол (KM5+420)/




Зураг 11. Нэг маягийн хөндлөн огтлол 7 – 7 /Шалган нэвтрүүлэх хэсгийн 12ш авто машины зогсоол (KM23+780)/



Зураг 12. Нэг маягийн хөндлөн огтлол 8 - 8 / Увс нуурын эргийн 307ш авто машины зогсоол (KM26+160)/

### 3.4. Дугуйн замын төлөвлөлт


Улаангом – Увс нуур чиглэлийн хатуу хучилттай авто зам барих ажлын зураг төсөв боловсруулах даалгаврын дагуу төлөвлөж буй авто замын баруун талаар дугуйн замыг ногоон байгууламжаар тусгаарлан төлөвлөсөн. Унадаг дугуйн замыг төлөвлөхөд тавигдах ерөнхий шаардлага MNS 5683: 2016 дагуу эсрэг хөдөлгөөнтэй, хоёр эгнээгээр зорчих дугуйн замын өргөн 2.5м байна. Дугуйн зам нь төлөвлөж буй замын баруун талаар 26.39км урт байх бөгөөд замын эхлэл, морь бариа, Увс нуурын эргийн авто машины зогсоолууд дээр дугуйн замын зогсоолуудыг төлөвлөсөн болно.



Зураг 13. Дугуйн зогсоол


### 3.5. Явган хүний зам

Явган хүний замыг 6см-н зузаантай 10см х 20см харьцаатай /В-22.5/ хүрэн, улаан хүрэн, цайвар шар өнгийн өнгөт хавтангуудаар өрж хийнэ. Өрөлтийг зураг төсөлд заасны дагуу зөвлөх болон захиалагчтай зөвшилцөн өрж өгнө. Хараагүй хүнд зориулсан хавтанг явган замд 30см өргөнтэйгөөр буюу нэг эгнээ хийнэ. Нарийвчилсан зургаас үзнэ үү.



Зураг 14. Явган хүний замын 100 х 200 х 60 -н хавтанг өрж байрлуулах

## ТАЙЛБАР БИЧИГ




























### 3.6. Авто замын тохижилт, тоноглол


Улаангом-Увс нуур чиглэлийн 26.4км хатуу хучилттай авто замд хашилт, чиглүүлэх хэрэгслүүд техникийн ерөнхий шаардлага MNS 4596:2014, 181 ширхэг босоо тэмдэг техникийн ерөнхий шаардлага MNS 4597:2013, 100510 у/м хэвтээ тэмдэглэл техникийн ерөнхий шаардлага MNS 4759:2013 стандарт норм дүрмийг баримтлан төлөвлөв. Захиалагч байгууллагын хүсэлтээр босоо тэмдгүүдийг бетонон суурьтай хийнэ. Замын эхлэл хэсэгт уулзварт мэдээллийн самбаруудыг байрлуулсан. Автобусны буудал, гарц, авто зогсоол, дугуйн зогсоол, дугуйн зам, замын өргөсөлт болон давуулах далан бүрт мэдээллэх тэмдгийг төлөвлөсөн. Зам хөндлөн гарч буй гарц бүрийн өмнө захиалагчийн хүсэлтээр хурд сааруулагч байрлуулж, анхааруулах болон мэдээллэх тэмдгийг тавьж өгсөн. Зам салж буй хэсгүүд, эгнээ хасагдаж байгаа газарт, бага радиустай эргэлт болон тахир замын өмнө анхааруулах тэмдэг мөн хурдны хязгаар, гүйцэж түрүүлэхийг хориглосон тэмдгийг төлөвлөсөн. Айлууд байрлах газраас 2 тийш 30, 30м-ын зайд малын гарц байгааг анхааруулсан. Авто замын аюултай хэсгүүдэд мөн зогс тэмдгийн өмнө 1.1 тэмдэглэгээг, ойртох хэсэгт 1.6 тэмдэглэгээг, үлдсэн хэсгүүдэд эгнээг тусгаарлах 1.5 тэмдэглэгээг, уулзвар дээр

## ТАЙЛБАР БИЧИГ

эгнээний хилийг 1.7 тэмдэглэгээ, орохыг хориглох хэсэгт 1.15.а тэмдэглэгээ, гарцуудын өмнө 1.11 тэмдэглэгээ, авто замын захыг 1.2 тэмдэглэгээ, дугуйн гарцын 1.14 тэмдэглэгээ, автобусны буудал бүрт 1.16 тэмдэглэгээ зэргийг байрлуулсан. 600-с бага радиустай эргэлтүүдэд чиглүүлэгч шонг замын 2 талаар, давуулах далан бүрт замын 2 талаар мэдээллэх шонгуудыг төлөвлөсөн. Авто зогсоолын хилийг 1.1 шугаман тэмдэглэгээгээр тусгаарласан ба зогсоол бүрт авто машины дугуй хязгаарлагчийг хийсэн. Дугуйн зогсоолууд дээр бетонон бэхэлгээтэй төмөр зогсоол төлөвлөсөн. Авто замын эхлэлээс 1 километр дутамд километрын мэдээллэх шонг байрлуулна.

ЗАМЫН БОСОО ТЭМДЭГЛЭГЭЭ					
Тэмдэг	Тэмдэглэлийн дурсгал	Салбар		Тоо	
		Байрлал	Зүүн		
Анхныгээр тэмдэг		18.а Өсгөл хэсэг /Даруун/	19-812 24-142 25-025	14200	4
		18.б Өсгөл хэсэг /Зүүн/	19-821 24-180 25-270		4
		19.а Талар хан/Баруун/	4-088	4-582	2
		19.б Талар хан /Зүүн/	6-078	6-843	2
		115.8 Зөн хэсгийн /Баруун/	0-096		1
		117 Хярд саруулагч	1-300 14-010 17-815 22-810 23-330 23-870 25-990	5-815 10-100 16-115 23-330 23-870	11
		118 Явган хүний зам	5-125 5-711 17-740 22-940 25-954	5-733 10-019 18-020 23-250	9
		122 Ман нурт газар зам	4-080 4-645 9-020 16-100 18-600 19-990 17-970 20-910	4-610 4-610 9-080 16-160 18-660 15-050 18-030 24-020	16
	Нийт				49
	Нэгдсэн тэмдэг		2.1 Өвчтөн хэргэмтэй	3-763 4-079 6-065 19-001 24-150 25-026	14208 14-590 16-855 19-835 24-290 25-280
		2.20 Гүйцэлтэй тэрэггүйн хэргэмтэй	14210 14-990 16-835 19-835 24-290 25-026	3-763 4-079 16-855 19-835 24-290 25-026	11
		2.21 Гүйцэлтэй тэрэггүйн хэргэмтэй тасалга	3-751 4-069 5-330 9-696 10-014 16-075 19-992 22-900 23-270 24-021 24-300 25-025 25-290	14210 14-010 14-010 10-014 16-055 19-992 22-900 23-270 24-300 25-025 25-290	17
		2.25 Хярдны дэвжээг хязгаарлах тасалга	1410 4-069 4-600 5-330 9-696 10-014 16-055 19-992 22-900 23-270 24-300 25-025	9-753 4-069 5-330 9-696 10-014 16-055 19-992 22-900 23-270 24-300 25-025	17
		3.3.а Туслах зам хийлгэх /Баруун/	5-340	5-480	2
		3.3.б Туслах зам хийлгэх /Баруун/	0-410	23-180	2
		3.3.в Туслах зам хийлгэх /Зүүн/	22-980		1
		3.4 Зөн талбайг зөв	3-020 3-415		2
Нийт				66	
Зогсоолын тэмдэг			4.4 Өсгөл хэсэг /Баруун хан	0-021 5-440	
		5.12.а Баруун хэргэмтэй	0-100	0-000	2
		5.17 Зогсоол	0-082 1-402 2-410 3-418 24-010 24-172	23-808	7
		5.18 Хярд саруулагч	5-490 5-665 16-780 16-780 16-950 17-765 17-965 22-980 23-180 23-120 23-840	5-490 5-665 16-780 16-780 16-950 17-765 17-965 22-980 23-180 23-120 23-840	20
		5.19.а.8 Явган хүний зам	1-408 1-424 5-374 9-869 10-860 11-860 22-492 23-862	5-081 9-861 11-870 23-100 23-171 23-176 23-866	14
		5.21 Чиглэлийн тэмдэглэлийн хязгаарлах бүлэг	0-081 11-870 11-870 23-100	5-374 9-860 11-860 23-050	8
		5.23 Чиглэлийн тэмдэглэлийн хязгаар	0-100	0-000 0-080	3
		Давуулах далангийн тэмдэглэлийн сонгодог	0-050 25-100 25-020	1-410 25-140 26-120	6
		7.4 Чиглэлийн тэмдэглэлийн тал /Хярд /Баруун/	0-082 1-410 3-425		4
	Нийт				66


**Давуулах далангийн тэмдэглэлийн сонгодог**




Ус давуулах далангийн мэдээллэх шонгийн дараа углан зургаасанд үүрчээ ус хурдтай суурилыг авто замын нийлэх хэргэмтэй, дээд углан зургаасанд хүртэл бүх гэдэрийн хэргэмтэй, хөдөлгөөнийг хориглоно.

Зураг 16. Замын босоо тэмдэг

# ТАЙЛБАР БИЧИГ




Зураг 17. Замын хэвтээ тэмдэглэгээ




Зураг 18. Замын тэмдэгийн суурь

# ТАЙЛБАР БИЧИГ




Зураг 19. Чигийн урьдчилсан заалтын тэмдгийн суурь




Зураг 20. Замын чиглүүлэгч шон

# ТАЙЛБАР БИЧИГ



Зураг 21. Авто зогсоолын дугуй хязгаарлагч



Зураг 22. Километрийн мэдээллэх шон



### 4. ХУЧИЛТЫН ХИЙЦИЙН ТАЙЛАН

---

#### 4.1. Үндэслэл

Увс аймгийн Засаг даргын 2021 оны 05 дугаар сарын 03-ны өдрийн 35/2021 дугаартай Улаангом-Увс нуур чиглэлийн хатуу хучилттай авто зам барих ажлын зураг төсөл боловсруулах даалгаврын дагуу төслийн авто замын хучилтын тооцоог хийж гүйцэтгэв.

Замын хучилтын хийцийг ажлын даалгавар, хөдөлгөөний хэтийн эрчим, тээврийн хэрэгсэл, тээвэр хийх ачааны нийт жин, ул хөрсний шинж чанар, байгаль цаг уураас үзүүлэх нөлөөлөл, замын онцлог шинж байдлыг харгалзан үзсэний үндсэн дээр асфальтбетон хучлагатайгаар төсөллөө.

#### 4.2. Асфальтбетон хучлагатай хучилтын тооцоо

Асфальтбетон хучлагатай хучилтын тооцоог AASHTO-ын (*AASHTO Guide for Design of Pavement Structures 1993*) аргачлалын дагуу хийж гүйцэтгэлээ. Хучилтыг хийцийн тооцоонд ашигласан параметруудийг дурдвал:

#### 4.3. Төлөвлөлтийн хугацаа-15 жил

Замын төлөвлөлтийн хугацааг их засвар хийх хугацаа хүртэл буюу 15 жилээр тооцлоо.

#### 4.4. Үйлчилгээний эхний түвшин- $P_i$ ба Үйлчилгээний эцсийн түвшин- $P_t$

Үйлчилгээний эхний болон эцсийн түвшинг AASHTO-ын (Page 1-8 of AASHTO Guide for Design of Pavement Structures 1993) аргачлалын дагуу шинээр баригдах замд 4.2 болон 2.5-аар тооцож авлаа.

#### 4.5. Жилийн хоногийн дундаж хөдөлгөөний эрчим-AADT

Төлөвлөж буй авто зам нь Увс аймгийн нутаг дэвсгэрт Увс нуур-Улаангом-Тариалан сумын нутаг дэвсгэрт баригдана. Авто замын хучилтын хийцийн найдвартай байдлыг хангахын тулд замын хөдөлгөөний эрчим хамгийн өндөр байх үе буюу 2021 оны 3-р улиралд хийсэн хөдөлгөөний эрчмийн судалгааг хучилтын хийцийн тооцоонд ашиглав.

Хөдөлгөөний эрчмийн тооллогын үр дүнг үндэслэн замын ашиглалтын үед төслийн замаар дамжин өнгөрөх жилийн хоногийн дундаж хөдөлгөөний эрчмийг

## ТАЙЛБАР БИЧИГ

Хүснэгт-8-д үзүүлсэн байдлаар төсөөлөв. Жил бүрийн хөдөлгөөний эрчмийг 5% өсөхөөр тооцсон.

*Хүснэгт-8. Жилийн хоногийн дундаж хөдөлгөөний эрчмийн төсөөлөл*

Жил	Жилийн тоо	Суудлын тэрэг	Бага даацын ачааны машин	Дунд даацын ачааны машин	Хүнд даацын ачааны машин	Жижиг оврын автобус	Том оврын автобус
2022		92	6	11	19	8	13
<b>Эрчмийн өсөлт (%)</b>		<b>5</b>	<b>5</b>	<b>5</b>	<b>5</b>	<b>5</b>	<b>5</b>
2023	1	97	6	12	20	8	14
2024	2	101	7	12	21	9	14
2025	3	107	7	13	22	9	15
2026	4	112	7	13	23	10	16
2027	5	117	8	14	24	10	17
2028	1	123	8	15	25	11	17
2029	2	129	8	15	27	11	18
2030	3	136	9	16	28	12	19
2031	4	143	9	17	29	12	20
2032	5	150	10	18	31	13	21
2033	1	157	10	19	32	14	22
2034	2	165	11	20	34	14	23
2035	3	173	11	21	36	15	25
2036	4	182	12	22	38	16	26
2037	5	191	12	23	39	17	27

### 4.6. Тээврийн хэрэгслийн төрөл

Тээврийн хэрэгслийн хөдөлгөөний эрчмийн судалгааг үндэслэн төслийн авто замаар суудлын тэрэг, бага даацын ачааны машин, дунд даацын ачааны машин, хүнд даацын ачааны машин, жижиг оврын болон том оврын автобус тус тус зорчихоор тооцоолсон. Тээврийн хэрэгслийн тэнхлэгээс авто замд үзүүлэх ачааллыг Хүснэгт-9-т үзүүлэв.

## ТАЙЛБАР БИЧИГ

*Хүснэгт-9. Тээврийн хэрэгслүүдийн тэнхлэгийн ачаалал*

№	Тээврийн хэрэгслийн төрөл	Тэнхлэгийн бүрэлдхүүн	Тэнхлэгийн ачаалал (кг)		
			Урд дан тэнхлэг	Хойд дан тэнхлэг	Хойд хос тэнхлэг
1	Суудлын тэрэг	1.1	900	1550	
2	Бага даацын ачааны машин	1.2	1200	2400	
3	Дунд даацын ачааны машин	1.2	2625	7900	
4	Хүнд даацын ачааны машин	1.22	9000		16000
5	Жижиг оврын автобус	1.1	1500	1860	
6	Том оврын автобус	1.2	7000	11500	

### 4.7. Эвдрэлийн коэффициент-VDF

Тээврийн хэрэгслийн тэнхлэгээс авто замд үзүүлэх эвдрэлийн коэффициентийг (VDF)-ийг тээврийн хэрэгслийн төрөл, тэдгээрийн тэнхлэгээс авто замд үзүүлэх ачааллаас хамааруулан тооцож Хүснэгт-3-т үзүүлэв.

*Хүснэгт-10. Эвдрэлийн коэффициент-VDF*

№	Тээврийн хэрэгслийн төрөл	Тэнхлэг тус бүрээс үзүүлэх эвдрэлийн коэффициент			Эвдрэлийн коэффициент-VDF
		Урд дан тэнхлэг	Хойд дан тэнхлэг	Хойд хос тэнхлэг	
1	Суудлын тэрэг	0.0003	0.0030		0.0034
2	Бага даацын ачааны машин	0.0011	0.0075		0.0086
3	Дунд даацын ачааны машин	0.0250	0.8785		0.9035
4	Хүнд даацын ачааны машин	3.4578		1.3084	4.7662
5	Жижиг оврын автобус	0.0027	0.0063		0.0090
6	Том оврын автобус	1.2654	3.9449		5.2102

### 4.8. 18 крп ачаалалтай тэнхлэгийн давтагдах тоо

Жилийн хоногийн хөдөлгөөний дундаж эрчим-AADT, тээврийн хэрэгслийн тэнхлэгээс авто замд үзүүлэх эвдрэлийн коэффициент-VDF, хөдөлгөөний эрчим хуваагдах итгэлцүүр-LDF тус тус ашиглан төслийн авто замаар төлөвлөлтийн 15 жилийн хугацаанд 18 крп ачаалалтай тэнхлэгийн давтагдах тоог тооцож, Хүснэгт-11-т үзүүлэв.

## ТАЙЛБАР БИЧИГ

Хүснэгт-11. 18 кр стандарт тэнхлэгийн давтагдах тоо  
(Улаангом-Увс нуур чиглэлийн хатуу хучилттай авто зам)

2022 оны тээврийн хэрэгсэл		Суудлын тэрэг	Бага даацын ачааны машин	Дунд даацын ачааны машин	Хүнд даацын ачааны машин	Жижиг оёрын автобус	Том оёрын автобус	Нийт стандарт ачаалал, сая
		<b>92</b>	<b>6</b>	<b>11</b>	<b>19</b>	<b>8</b>	<b>13</b>	
Өсөлт (%)		<b>5</b>	<b>5</b>	<b>5</b>	<b>5</b>	<b>5</b>	<b>5</b>	
VDF		0.0034	0.009	0.904	4.766	0.009	5.210	
LDF		0.5	0.5	0.5	0.5	0.5	0.5	
Он	Жилийн тоо							
2023	1	57	9	1,814	16,527	13	12,361	0.031
2024	2	117	19	3,718	33,880	27	25,341	0.094
2025	3	179	30	5,718	52,101	41	38,969	0.191
2026	4	245	40	7,818	71,232	56	53,279	0.324
2027	5	314	52	10,023	91,321	72	68,304	0.494
2027 оны тээврийн хэрэгсэл		117	8	14	24	10	17	
Өсөлт (%)		<b>5</b>	<b>5</b>	<b>5</b>	<b>5</b>	<b>5</b>	<b>5</b>	
2028	1	387	64	12,338	112,414	89	84,080	0.703
2029	2	463	76	14,768	134,561	107	100,645	0.954
2030	3	543	90	17,321	157,816	125	118,039	1.248
2031	4	627	104	20,000	182,234	144	136,302	1.587
2032	5	715	118	22,814	207,872	165	155,478	1.974
2032 оны тээврийн хэрэгсэл		150	10	18	31	13	21	
Өсөлт (%)		<b>5</b>	<b>5</b>	<b>5</b>	<b>5</b>	<b>5</b>	<b>5</b>	
2033	1	808	133	25,769	234,792	186	175,614	2.411
2034	2	905	149	28,871	263,059	209	196,755	2.901
2035	3	1,008	166	32,129	292,739	232	218,955	3.447
2036	4	1,115	184	35,549	323,902	257	242,263	4.050
2037	5	1,227	203	39,140	356,624	283	266,738	4.714

### 4.9. Уян харимхайн модуль-Mr

Инженер-геологийн судалгааг “Эко Гидро Гео” ХХК хийсэн бөгөөд судалгааны тайлангаас үзэхэд төслийн талбайд техноген гаралтай асгамал хөрс, дөрөвдөгчийн настай, аллюви-пролювийн гаралтай элсэн чигжээстэй хайр, хайрган ул хөрс илэрсэн.

Төслийн авто замын дагууд нийт 12 төрлийн ул хөрс тархсан байгаа бөгөөд хучилтын хийцийн тооцоонд хэв гажилтын модуль хамгийн бага байх элсэн хөнгөн шавар ул хөрс, тоосорхог шавар ул хөрсийг инженер-геологийн элемент болгож, хучилтын хийцийн тооцоонд ашиглав.

Ул хөрсний физик механик шинж чанарын үзүүлэлтүүдийг Хүснэгт-12-д үзүүлэв.

## ТАЙЛБАР БИЧИГ

*Хүснэгт-12. Ул хөрсний норматив тооцооны үзүүлэлт*

ИГЭ-ийн дугаар	Хөрсний төрөл	Замын холбоослог ул хөрсний тооцооны үзүүлэлтүүд			
		Хэв гажилтын модуль $E_{хөрс}$ , МПа	Дотоод үрэлтийн өнцөг $\phi_{хөрс}$ , град	Барьцалдалтын хүч $C_{хөрс}$ , МПа	Тооцооны эсэргүүцэл $R_0$ , кПа
ИГЭ-8	Элсэрхэг хөнгөн шавар ул хөрс	42	16	0,015	220
ИГЭ-9	Тоосорхог шаварлаг ул хөрс	42	16	0,015	196

Хүснэгтээс үзэхэд дээрх 2 хөрсний хэв гажилтын модуль нь 42МПа байгаа бөгөөд үүнийг ачаа даацын харьцаа (CBR) –д хөрвүүлэн тооцож үзэхэд CBR=4.1% байхаар байна. Иймд хучилтын хийцийн тооцоонд ул хөрсний ачаа даацын харьцаа CBR=4% байхаар тооцлоо.

Ул хөрс нь нарийн ширхэглэлтэй материал байгаа тул уян харимхайн модулийг  $M_r=1500 \times CBR$  томъёогоор тодорхойлов.

### 4.10. Стандарт хэлбэлзэл- $S_o$

Стандарт хэлбэлзэл гэдэг нь урьдчилан төсөлсөн замын хөдөлгөөний эрчим болон замын ашиглалтын нөхцөл байдлын үзүүлэлтүүдийн хосолмол хэлбэлзэл бөгөөд хучилтын тооцоонд AASHTO-ын (*Page 1-62 of AASHTO Guide for Design of Pavement Structures 1993*) аргачлалын дагуу 0.45-аар авлаа.

### 4.11. Найдваржилт – $R$

Замын найдвартай байдал нь ашиглалтын явцад төлөвлөсөн хөдөлгөөний эрчмийн өсөлт, байгаль цаг уурын нөлөөллөөс үүссэн нөхцөл байдал зэргээр илэрхийлэгдэх бөгөөд энэ тооцоонд AASHTO-ын (*Table 2-2 of AASHTO Guide for Design of Pavement Structures 1993*) аргачлалын дагуу 90%-иар авлаа.

### 4.12. Хучилтын үеийн коэффициент- $a_i$

Энэ нь хучилтын үеүдийн зузааныг хучилтын хийц тус бүрийн хүчин чадал руу шилжүүлэх коэффициент бөгөөд AASHTO-ын (*Page II-20,22 of AASHTO Guide for Design of Pavement Structures 1993*) аргачлалын дагуу өнгө асфальтбетон, суурь

асфальтбетон, цементээр бэхжүүлсэн буталсан чулуун суурь, хайрган суурийн доод үеүдэд  $a_{AWC}=0.44$ ,  $a_{ABC}=0.44$ ,  $a_{BC}=0.23$ ,  $a_{SB}=0.12$  байхаар тус тус авлаа.

### 4.13. Үеүдийн шүүрүүлэлтийн коэффициент- $m_i$

Шинээр баригдаж буй замд үеүдийн шүүрүүлэлтийн коэффициентийг AASHTO-ын (Table 2-4 of AASHTO Guide for Design of Pavement Structures 1993) аргачлалын дагуу  $m_i=1$  байхаар авсан.

### 4.14. Стандарт зөрүү- $Z_r$

Стандарт зөрүүг найдвартай байдлын коэффициентээс тооцож гаргасан ба  $R=90\%$  байх үед  $Z_r = -1.282$  байхаар гарч байна. AASHTO (Table 4-1 of AASHTO Guide for Design of Pavement Structures 1993).

### 4.15. Хөлдөлтийн зэрэглэл- $\phi$

Материалын бүрэлдэхүүн хэсгээс хамаарах шаварлаг ул хөрсний хөлдөлтийн зэрэглэлийг 2.5мм/өдөр байх тооцов. (AASHTO Depends on material properties and grain size. from Fig G-6)

### 4.16. Хөлдөх магадлал-PF

Ул хөрсний хөлдөх магадлалыг 60% байхаар тооцоонд ашиглав.

### 4.17. Үйлчилгээний түвшингийн боломжит хамгийн их алдагдал- $\Delta PSIMAX$

Ул хөрсний хөлдөлт гэсэлтээс хамаарах үйлчилгээний түвшингийн боломжит хамгийн их алдагдлыг 75% байхаар тооцов.

Арван таван жилийн хугацаанд төслийн авто замаар 18kip-ийн ачаалалтай тэнхлэг 4.714 сая дамжин өнгөрөхөөр байгаа бөгөөд дээр дурдсан параметруудийг ашиглан шаардлагатай хучилтын хийцийн хүчин чадлыг тооцож үзэхэд  $SN=5.0067$  байсан.

Хучилтын үеүдийг :

- Өнгө асфальтбетон-30мм
- Суурь асфальтбетон-50мм
- Цементээр бэхжүүлсэн буталсан чулуун суурь-250мм
- Хөлдөлтөөс хамгаалах үе-300мм хийцтэйгээр төлөвлөж тооцоход хучилтын хийцийн хүчин чадал/ $SN=5.053$  буюу  $SN_{\text{төлөвлөлт}} > SN_{\text{бодит}}$  байв.

## ТАЙЛАР БИЧИГ

Хучилтын тооцоог хавсаргав.

### AASHTO Method of Pavement Design

Annex 1

Project : Улаангом-Увс нуур чиглэлийн хатуу хучилттай авто зам

#### INPUT DATA

		Remarks
<b>Serviceability Indices</b>		
$P_i = 4.2$	(Initial)	
$P_o = 2.5$	(Lowest)	
$W_{18} = 4.714$	i.e. 4.71E+6 ESAL	
$M_R = 6000$	(1500* CBR)	
$S_o = 0.45$	In general it is 0.4 to 0.5	
$R = 0.9$		
<b>Layer Strength coefficients</b>		
$a_1 = 0.44$	For Bituminous Concrete	
$a_2 = 0.44$	For Dense Bituminous Concrete	
$a_3 = 0.23$	For Cement Treated Crushed Stone Base	
$a_4 = 0.12$	For Granular Sub Base	
<b>Drainage coefficients</b>		
$m_1 = 1$	For Bituminous Concrete	
$m_2 = 1$	For Dense Bituminous Concrete	
$m_3 = 1$	For Cement Treated Crushed Stone Base	
$m_4 = 1$	For Granular Sub Base	

#### CALCULATIONS

$Z_R = -1.282$	For R=0.90	Terminal serviceability loss equals to serviceability loss due to traffic minus serviceability loss due to frost heave (1.7 - 0.177)
$\Delta(\text{PSI}) = 1.46$	(4.2-2.5)	

<b>Calculated <math>SN_e</math> Value =</b>	<b>5.0067</b>	Update Structural Number
$\text{Log}(W_{18})$		<b>6.6734</b>
$Z_R \times S_o$	=	-0.577
$9.36 \log(\text{SN}+1) - 0.2$	=	7.088
$((\text{LOG}(\Delta \text{PSI}) / (4.2 - 1.5), 10) / (0.4 + (1094 / (\text{SN} + 1)^{0.78})))$	=	-0.533
$2.32 \times \text{LOG}(M_R) - 8.07$	=	0.695
$\text{Log}(W_{18})$		<b>6.6734</b>

#### Layer Thickness and structural number calculations

Layer thicknesses (in mm)	Layer thicknesses (in inches)	Structural Numbers	Adopted layer thickness (in mm)	Remarks
$D_1 = 30$	1.178	$SN_1 = 0.5180$	$D_1 = 30$	
$D_2 = 50$	1.963	$SN_2 = 1.3820$	$D_2 = 50$	
$D_3 = 250$	9.815	$SN_3 = 3.6400$	$D_3 = 250$	
$D_4 = 300$	11.779	$SN_4 = 5.0530$	$D_4 = 300$	
<b>Total = 630</b>		<b><math>SN_e = 5.0530</math></b>	<b>Total = 630</b>	

**AASHTO Method of Pavement Design**

Annex 1

**Calculation of Serviceability loss due to Frost Heave**

Design Period	=	15	Years	Analysis Period
Frost Heave Rate ( $\phi$ )	=	2.5	mm/day	Depends on material properties and grain size (from Fig G-6)
Probability of Frost Heave ( $P_F$ )	=	60	%	
Maximum Potential Serviceability Loss, $\Delta PSI_{MAX}$	=	0.75		Depends on Drainage Quality & Frost Penetration Depth (from Fig G-7)
Serviceability loss due to frost heave, $\Delta PSI_{FH}$	=	0.237		



## 5. УС ЗҮЙН СУДАЛГААНЫ ТАЙЛАН

### 5.1. Судалгаа явуулсан үндэслэл

Авто замын байгууламжийн зураг төслийг “Эн Би Си Си” ХХКомпани гүйцэтгэж Инженер-гидрологич Ж.Баяраа /Монгол Улсын Зөвлөх Инженер/ замын зурвасын дагууд буй гүүрийн барилга байгууламжийн хөндлөн гарах гол, хуурай сайрын ус зүйн судалгааг 2022 оны 04-р сард хээрийн хайгуул судалгааг явуулж мөн оны 05-р сарын 01-наас 05-р сарын 30-ний хооронд суурин боловсруулалт тооцооны ажлыг хийж гүйцэтгэлээ.

### 5.2. Судалгааны аргачлал


Уг ажлыг гүйцэтгэхдээ барилга байгууламжийн ажлын зургийн үе шатны зураг төсөл боловсруулахад шаардагдах БНБД-ийг удирдамж болгон техникийн нөхцөлийг бүрдүүлэх хээрийн судалгаа, суурин боловсруулалтын ажлыг гүйцэтгэлээ.

Барилга байгууламжийн байршлыг М1:100 000 бүхий байр зүйн зурагт буулгаж, усалгааны талбайн хөрсний физик-механик шинж чанарын болон бүтцийн үзүүлэлтийг тодорхойлох зорилгоор онцлог газраас хөрсний дээж авч лабораторийн шинжилгээ хийв. Хээрийн хайгуул судалгааг гүйцэтгэх явцдаа орон нутгийн оршин суугчдаас аман судалгаа авч ажиллав.

Дээрх ажлыг хийж гүйцэтгэхийн тулд М1:100 000-ийн байр зүйн зураг, Түргэн, Улаангом цаг уурын станцуудын олон жилийн ажиглалтын материал болон сав нутагт урьд нь хийгдсэн бусад /хөдөө аж ахуйн зориулалтаар/ хайгуул судалгааны материалуудыг авч ашиглалаа.

### 5.3. Судалгааны байршил:

Авто замын зурвас байрлаж буй судалгааны талбай нь газар зүйн байрлалын хувьд Монгол Алтайн уулархаг их мужийн Хархираа-Түргэний уулсын дэд мужид багтаж далайн түвшнээс дээш 1900м-ийн өндөрт, ус зүйн хувьд Төв Азийн гадагш урсацгүй голуудын ай савд, засаг захиргааны хувьд Увс аймгийн Улаангом, Тариалан сумдын нутагт оршино.



Зураг 23. Авто замын байршлын тойм зураг М1:2 000 000

#### 5.4. Гадаргын хотгор гүдгэр

Судалгаанд хамрагдаж буй районд зонхилж ухаа гүвээт тал, талархаг гадаргатай. Судалгааны районы ихэнх хагаст тархсан уул, цав толгодууд нь харьцах өндрөөрөө хэдхэн арван метр байхаас гадна хажуу нь маш налуу, орой нь шовх хэлбэртэй юм. Тэдгээрийн хооронд жижиг хотос буюу тэгш гадарга өргөн хөндийнүүд нь өргөн, налуу хажуутай, тэгшивтэр ёроолтой юм. Ухаа гүвээт талын дунд энд тэнд цав толгод товойж харагдана. Эдгээр уул, толгодын хажуу нь шулуун төдийлөн эгц биш, орой нь хааяа шовх байдалтай байдаг.



Зураг 24. Авто замын зурвасын байршлын тойм зураг М1:1 000 000

### 5.5. Уур амьсгал

Судалгааны район нь Монгол орны бусад нутгийн нэгэн адил эх газрын эрс тэс уур амьсгалтай бөгөөд ерөнхийдөө өвөл нь удаан (цас ихтэй, хүйтэн), зун нь богино (халуун байх ба үе үе цочир хүйтрэн сэрүүсдэг), хур чийг харьцангуй багавтар, хавар, намар хөндий дагасан салхи их тохиолдох хуурай, сэрүүн уур амьсгалын бичил мужид оршино.

Увс аймгийн нутгийн хотгор гүдгэрийн ялгаа их байгаа явдал нь уур амьсгалын эрс тэс ялгаатай байдлыг улам их болгодог.

## ТАЙЛБАР БИЧИГ

Уур амьсгалын үндсэн үзүүлэлтийг Улаангом станц, Түргэн харуулын олон жилийн ажиглалтын материалыг ашиглан агаарын температур, агаарын чийгшил, салхины горим гэсэн үзүүлэлтээр өгч хүснэгтээр харуулав.


### **Агаарын температур**

Судалгааны район нь олон жилийн агаарын температур  $-2.4...-3.70\text{C}$  байгаа нь сэрүүвтэр бүсэд багтахыг харуулна. Агаарын температур хавар 4-р сарын сүүлчийн арав хоногт  $00\text{C}$ -ийг давж дулаарч, хамгийн дулаан 7-р сард  $+18-19.20\text{C}$  дундажтай байх ба үнэмлэхүй их нь  $+30.5-36.60\text{C}$  байна. Намар 10-р сарын эхний арав хоногт  $00\text{C}$ -ийг давж хүйтэрч, хамгийн хүйтэн 1-р сард  $-29.00\text{C}$ -ээс  $-32.90\text{C}$  дундажтай байх ба үнэмлэхүй бага нь  $-43.1-49.60\text{C}$  байна. Агаарт цочир хүйтрэлт ажиглагдах анхны хугацаа нь намар 8-р сарын сүүлчийн арав хоногт, эцсийн хугацаа нь хавар 5-р сарын сүүлчээр ажиглагдаж цочир хүйтрэлгүй үеийн үргэлжлэх хугацаа 159-165 орчим хоног байна.

### **Сарын дундаж агаарын температур**

Хүснэгт 13

	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	Дундаж
Улаангом	-32.9	-30.2	-18.8	-0.4	11.3	17.9	19.2	16.9	10.2	0.2	-11	-26.7	-3.7
Түргэн	-29	-26.4	-15.5	0.9	12.3	11.7	18	16.8	11.7	2.4	-12.3	-25.4	-2.4



Агаарын температурын жилийн явц

## ТАЙЛБАР БИЧИГ

### Хөрсний температур

Бүс нутгаар хөрсний гадаргын температурын олон жилийн дундаж температур -1-с +10С байх ба агаарын температурын жилийн явцтай нэгэн адил 1 дүгээр сард хамгийн хүйтэн (үнэмлэхүй бага температур -47-с -520С), 7 дугаар сард хамгийн дулаан (үнэмлэхүй их температур +49-с 610С) байна. Хөрсний гүнд улирлын хөлдөлтөөр 3.2м хүрч хөлдөх ба хөрсний гүнд ховор алаг цоог тархацтай цэвдэгтэй бүсэд оршино. Хөрсний улирлын хөлдөлтийн норматив гүн нь шавар, шавранцар хөрсөнд 2.2м, элсэнцэр, жижиг ширхэгтэй элсэн хөрсөнд 2.7м, том ширхэт элсэн хөрсөнд 2.9м, том хэмхдэст хөрсөнд 3.2м тус тус байна.


Хөрсний гадаргын дундаж температур

Хүснэгт 14

	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	Дундаж
Улаангом	-33	-29	-17	3	16	24	24	21	13	2	-10	-26	-1
Түргэн	-30	-25	-12	3	17	25	25	22	15	4	-7	-23	1



Хөрсний температур




Зураг 25 . Цэвдгийн мужлалт


### Чийгшил ба тунадас

Энэ бүс нутагт газар зүйн байрлал болон хур тунадасны хэмжээ зэргээс хамаарч агаарын чийгшил нэлээд дутмаг байдаг. Хүйтний улиралд Түргэнд агаарын харьцангуй чийгшил 74-67%, харин дулааны улиралд 45-64% байх ба жилийн явц нь өвөл, зун их утгаа авч хавар, намар хамгийн бага хэмжээтэй болдог. Уг бүс нутагт олон жилийн дундаж байдлаар 137.2-142.5 мм тунадас унах ба түүний 85 орчим хувь нь зөвхөн дулааны улиралд буюу 5-9 дүгээр саруудад ордог байна. Анхны цас 10 дүгээр сарын дунд арав хоногт ажиглагдаж өвөл 5-10 см зузаан цасан бүрхүүл 117-149 хоног тогтож 4 дугаар сарын дунд арав хоногт эцсийн цас ажиглагдах ба 3 дугаар сарын дундаас хайлж эхэлдэг. Цасны нягт 0.14-0.15 г/см<sup>3</sup> байдаг.


## ТАЙЛБАР БИЧИГ



*Хур тунадасны жилийн явц*



*Цасан бүрхүүлтэй өдрийн тоо*




*Цасан бүрхүүлийн дундаж зузаан ба нягт*



## ТАЙЛБАР БИЧИГ

### Салхи

Улаангомьн орчимд өмнө, баруун өмнө, баруун хойд ба хойд зүгийн салхи зонхилох бөгөөд салхины хурд олон жилийн дунджаар 1.3-1.7 м/сек байх ба олон жилийн ажиглалтын материалаас үзэхэд ажиглагдсан салхины дээд хэмжээ 24.0м/сек хүрч байжээ. Тус бүс нутагт 15м/сек-ээс дээш хүчтэй салхитай өдрийн тоо харьцангуй бага байдаг байна. 100 жилд тохиолдож болох салхины хурдны дээд хэмжээ 42.0м/с байна. Салхины чиглэл бүрийн давтагдлын диаграммыг Улаангом станцаар үзүүлэв.




Салхины чиглэл бүрийн давтагдлын диаграммыг Улаангом станцаар үзүүлэв.






## ТАЙЛБАР БИЧИГ



### 5.6. Авто замын уур амьсгалын нөхцөл

Авто зам төлөвлөж буй газар нь Монгол орны авто замын уур амьсгал, геотехникийн нөхцөлийн **IIВ** буюу тал хээрийн дэд бүсэд хамаардаг.



Зураг 26. Авто замын уур амьсгалын бүсчилэл

## ТАЙЛБАР БИЧИГ

Энэ бүсийн тодорхойлолт нь:

-Олон жилийн цэвдэг чулуулаг алаг цоог болон ховор алаг тархсан, улирлын хөлдөлт-гэсэлттэй, хүйтний овойлттой болон суумтгай лёсс маягийн хөрс өргөн тархсан

-Ойт хээртээ цасархаг, цас борооноос намаг шавар ихтэй, бороорхог, аянгалаг, хээр талдаа цас нимгэн нягтархаг, салхитай, хахир хүйтэн жаварлаг. Хөрс чулуулаг гүн хөлддөг.

-Газар хөдлөлийн 6-7 балл

### Бүсийн үндсэн тодорхойлолт

Бүсийн дугаар, нэр	Дэд бүсийн индекс	Бүсийн товч тодорхойлолт	Авто замын гео уур амьсгал, гео физикийн онцлог
II хээрийн авто замын уур амьсгалын бүс	IIВ. уулын завсар хоорондын тал хээрийн дэд бүс	-Бэсрэг уулт хээр, хээр талын авто замын уур амьсгалын хуурай-хүйтэн сэрүүвтэр хахир, хуурайдуу сэрүүвтэр хүйтэн хахирлаг дэд муж.	-Олон жилийн цэвдэг чулуулаг алаг цоог тархсан, авто замын уур амьсгалын улирлын хөлдөлт- гэсэлттэй. Уулархаг хээртээ цасархаг, цас борооноос намаг шавар ихтэй, бороорхог, аянгалаг, хээр талдаа цас нимгэн нягтархаг, салхитай, хахир хүйтэн жаварлаг.

Энэ бүсийн зарим онцлог үзүүлэлтүүдийг доорх байдлаар үзүүлэв.

### Улирлын үргэлжлэх хугацаа

Дэд бүс	Өвөл			Хавар		Зун		Намар
	Эхлэх	Дуусах	Үргэлжлэх хоног	Дуусах	Үргэлжлэх хоног	Дуусах	Үргэлжлэх хоног	Үргэлжлэх хоног
IIВ	1-9.XI 5.XI	15-24.III 19.III	126-143 134	6-12.Y 9.Y	45-52 48	8-19.IX 13.IX	112-156 129	44-54 49

#### Тайлбар:

\* Өвлийн дуусах хугацаа хаврын эхлэл, хаврынх зуны эхлэл, зуных намрын эхлэл, өвлийн эхлэл намрын дуусах хугацаа болно.

## ТАЙЛБАР БИЧИГ

### Хөрс, агаарын температурын ( °С) үзүүлэлт

Дэд бүс	Хөрсний гадаргын температур, °С				Агаар орчны дундаж температур		
	Олон жилийн дундаж	Хамгийн халуун	Хамгийн хүйтэн	0° нэвчих гүн, см*	Олон жилийн дундаж	Хамгийн хүйтэн сарын	Хамгийн дулаан сарын
<b>IIВ</b>	+0...+3	60-65	-41...-45	250-350	-2...+2	-20...-25	15...20

**Тайлбар:**

\* -0°С нэвчих гүн ул хөрсний төрлөөс хамаарах тул дээд, доод хязгаарыг авав.

### Хөрсний хөлдөлт-гэсэлтийн уур амьсгалын хугацаа

Дэд бүс	Хөлдөлт			Гэсэлт		
	Эхлэх	Дуусах	Хоног	Эхлэх	Дуусах	Хоног
<b>IIВ</b>	20-30.X 25.X	15.II-30.IY 5.IY	120-195 160	15.III-10.IY 25.III	15.IY-31.Y 23.IY	20-50 35

### Хөрсний хөлдөлт-гэсэлтийн норматив гүн

**IIВ** дэд бүсэд: **2.5м, 3.0м, 3.2м, 3.5м**

\*Тайлбар: 1 дэх тоо нь шавар, шавранцар, 2 дахь тоо нь элсэнцэр тоосорхог, 3 дахь тоо нь том болон дунд зэрэг элс, хайргархаг, 4 дэх тоо нь том хэмхдэст хөрсний цэвдэгтэй нутагт ул хөрсний гэсэлтийн цэвдэггүй нутагт ул хөрсний улирлын хөлдөлтийн норматив гүн, м-ээр болно.

### Авто замын барилгын үйлдвэрлэлийн ажил явуулахад тохиромжтой болон тохиромжгүй улирлын үеүүд

Дэд бүс	Дулааны улирал *			Хүйтний улирал
	Эхлэх	Дуусах	Хоног	Хоног
<b>IIВ</b>	10.IY	19.X	192	173

**Тайлбар:**

- Авто замын барилгын үйлдвэрлэлийн хүйтний улирлын эх нь дулааны улирлын төгсгөл, хүйтэн улирлын төгсгөл нь дулааны улирлын эх болдог

## ТАЙЛБАР БИЧИГ

### Авто замын уур амьсгалын жилийн 4 улирлын салхины хурд, агаарын даралт, харьцангуй чийгшил

Дэд бүс	Салхины хурд, м/с				Даралт, мм Hg баганын өндрөөр	Харьцангуй чийгшил, %
	Өвөл	Хавар	Зун	Намар		
<b>ИВ</b>	1.6-4.0	3-7	2-4	2.5-5.5	600-650	50-60

### Хээр гадаа ажиллах авто замын ажилчдын хөдөлмөрийн био уур амьсгалын нөхцөл

Дэд бүс	Хүчилтөрөг -чийн нягт, г/см <sup>3</sup>	Хувцас хунарын дулаан чанар, КЛО(хүндэвтэр ажлыг нөхцөлөөр тооцов)			Уур амьсгал хүний биед, хоног		
		Өвлийн	Хавар, намрын	Зуны	Таатай	Цочроох	Хурц
<b>ИВ</b>	250-260	4.6-5.5	2.8-3.0	1.5-1.7	175-190	110-120	80-90

### Авто замын үйлдвэрлэл, замчдын хөдөлмөрт уур амьсгалын нөлөөллийг үнэлэх итгэлцүүрүүд

Дэд бүс	Нөлөө үйлчлэлийн итгэлцүүр				
	Хүйтний	Хахирын	Халууны	Хур тунадасны	Чийгшлийн
<b>ИВ</b>	1.00	1.00	1.00	1.00	1.00

### Авто замын уур амьсгалын бүсүүдэд халуун асфальт бетон хольц бэлтгэж дэвсэхэд тохиромжтой хугацаа

Дэд бүс	Асфальт болон замын хучилт		
	Эхлэх	Дуусгах	Хоног
<b>ИВ</b>	18.IY-16.V (02. V)	15. VIII-19. IX (01.IX)	91-154 (122)

### Авто замын уур амьсгалын бүсүүдэд хүйтэн, бүлээн асфальт бетон хучилт хийхэд тохиромжтой хугацаа

Дэд бүс	Асфальт болон замын хучилт		
	Эхлэх	Дуусгах	Хоног
<b>ИВ</b>	03. III-30.III (16. III)	30.X-04.XII (15.XI)	220-278 (250)

ТАЙЛБАР БИЧИГ

Улаангом станцын ажиглалтын үзүүлэлтүүд

Үзүүлэлт	Сар	I	II	III	IV	V	VI	VII	VIII	IX	X	XI	XII	Жил
Агаарын дундаж температур (°C)		-32.9	-30.2	-18.8	-0.4	11.3	17.9	19.2	16.9	10.2	0.2	-11	-26.7	-3.7
Агаарын үнэмлэхүй их температур (°C)		-12.0	-6.2	2.4	28.0	35.9	33.7	36.6	36.4	28.4	24.7	9.1	-3.8	36.6
Агаарын үнэмлэхүй бага температур (°C)		-49.6	-46.1	-40.2	-24.7	-8.3	-3.1	0.4	0.2	-8.7	-21.7	-39.1	-47.3	-49.6
Хөрсний гадаргын дундаж температур (°C)		-33.0	-29.0	-17.0	3.0	16.0	24.0	24.0	21.0	13.0	2.0	-10.0	-26.0	-1.0
Хөрсний гадаргын үнэмлэхүй их температур (°C)		-10.0	-1.0	19.0	17.0	58.0	63.0	61.0	60.0	49.0	39.0	19.0	-2.0	63.0
Хөрсний гадаргын үнэмлэхүй бага температур (°C)		-52.0	-48.0	-42.0	-29.0	-11.0	-7.0	2.0	-9.0	-13.0	-27.0	-41.0	-49.0	52.0
Хөрсний гүний температур (°C)	0.2	-17.8	-16.4	-8.6	3.4	11.9	17.9	19.7	18.0	12.0	3.0	-7.2	-14.9	-1.9
	0.4	-15.3	-14.1	-6.7	1.3	9.3	15.1	17.6	15.7	11.7	4.4	-4.0	-11.8	-0.9
	0.6	-13.0	-12.8	-7.3	0.3	7.0	12.6	15.6	15.7	11.8	5.4	-1.9	-8.7	1.0
	0.8	-10.5	-11.1	-6.8	-0.7	5.1	10.5	13.3	13.8	11.6	6.3	-0.2	-7.2	2.1
	1.2	-6.9	-8.1	-6.1	-1.8	2.5	7.0	10.6	12.2	11.0	7.2	2.0	-3.0	2.2
	1.6	-3.8	-6.0	-5.2	-2.0	1.1	5.0	8.6	10.6	10.1	7.5	3.3	-0.4	2.4
2.4	-0.6	-2.9	-3.7	-2.0	-0.4	1.9	5.4	8.0	8.5	7.4	4.5	1.6	2.3	
3.2	0.5	-0.6	-1.9	-1.4	-0.4	0.4	3.2	5.9	7.1	6.7	4.8	2.5	2.2	
Хур тунадасны нийлбэр (мм)		2.3	2.2	3.9	3.8	7.3	22.3	39.5	22.6	15.1	4.6	8.5	4.1	137.2
Хоногийн хамгийн их тунадас (мм)		5.1	3.7	8.8	10.8	27.0	32.5	66.8	27.7	30.4	15.9	20.2	10.1	66.8
Бороотой өдрийн тоо (хоног)					0.8	4.3	7.2	10.5	7.9	4.6	0.2			35.5
Цасан бүрхүүлтэй өдрийн тоо (хоног)		31.0	28.0	31.0	9.2	1.0				1.0	0.9	18.2	31.0	149.3
Цасны дундаж зузаан (см)		5.0	7.0	2.0	1.0						1.0	2.0	4.0	7.0
Салхины дундаж хурд (м/с)		0.7	0.8	1.0	1.5	2.0	1.6	1.3	1.4	1.3	1.3	1.1	1.9	1.3

### 5.7. Ус зүйн тооцооны судалгааны тайлан


Судалгааны гүүр нь Төв Азийн гадагш урсацгүй голуудын ай савд багтах Увс нуурын ус хураах талбайд буюу Хархираа голын ус хураах талбайд оршино. Нийт нутагт гадаргын усан сүлжээ харьцангуй элбэгтэй.

Алтайн сүрлэг өндөр уулсын ам хавцал бүрээс усаждаг дээрх голуудад борооны ус үндсэн тэжээл нь болох боловч хур цас, мөсөн гол, гүний ус багагүй нэмэр болдог. Жилийн бүх урсцын 25-40%-ийг зуны (7-9 сар) хур борооны үеийн ус эзлэх учраас урсцын улирлын хувиарлалт нэлээд жигд, ялангуяа хаврын шар усны үерийн дараах гачиг үед урсац төдийлөн буурдаггүй нь мөнх цас мөсөн голын нөлөөтэй шууд хамааралтай байдгаас шалтгаална. Ус хураах талбайн өндөр уулархаг хэсэгт намар эрт хүйтэрч бороо хур эрс татрах учраас урсац намар, өвлийн гачиг үе эрт (9-р сард) эхэлж урт удаан хугацаагаар үргэлжилдэг. Зуны хур борооны үер тухай жилийн хур тунадасны унах явцаас шалтгаалж олон янз байдаг ба ямарч үед саваа хальж үерлэж байгаагүй байна. Гол 10-р сарын эхээр зайрмагтаж эхлэн өвлийн улиралд цутгал голуудын ихэнх нь ёроолдоо хүрч хөлдөж урсацгүй болдог. Голын уртад аль ч хэсэгт халиа дошин ажиглагддаг.

#### Голын тухай ерөнхий ойлголт

**Хархираа /Гашууны/ гол** нь Төв Азийн гадагш урсацгүй голуудын ай савд /Их нууруудын савд/ багтана. Хархираа, Түргэний уулсын ноён оргил Цагаан Дэглий уулын өвөр хэсгээс эх авах Чигээчний хэв, Түргэн, Хархираа, Дэлгэр зэрэг жижиг гол нийлж Хархираа гол болон цааш урсаж Увс нуурт цутгадаг. Хархираа голд түр урсгал бүхий олон сайр /гол/ цутгадгаас хамгийн том нь Цагаан хөтлийн амны сайр юм. Ус хураах талбайд ой мод бүхий уулс талбайн 8.6%-г эзэлнэ.

Гол эхэндээ 30-50 метрийн өргөнтэй хавцлаар урсаж уулнаас мултармагц Тариалан сумын төвийн орчмоос маш олон салаалж задгайрна. Голын хөндийд бургас улиас шигүү ургасан, голын татам нь 60-90 метр өргөн, гол нь татам дотроо олон салаалдаг. Татмын өргөн нь төгсгөлдөө өргөсөж 250-400 метр болдог.



★ - Ус зүйн харуул

Зураг 27. Голуудын ус хураах талбайн тойм зураг М1:1 000 000

Голын голдирлын тогтворжилт муу, үерийн дараа үргэлж өөрчлөгдөж байдаг. Голын Увс нуурт цутгаж буй хэсэгт уналт нь багасаж улмаар их хэмжээний талбай эзэлсэн намаг үүсгэдэг. Голын өргөн 10-40 метр, гүн нь 0.25-0.5 метр, усны урсгалын хурд ойролцоогоор 1.5 м/сек байдаг.

Өвөл голын нийт уртад татамдаа дүүрч халиа үүсгэн хөлддөг. Хавар 5-р сарын эхээр хайлж эхлэх ба хаврын шар усны үер мөн сарын сүүлчээр ажиглагддаг. Зарим жилд хаврын гачиг үе ажиглагдана. Хур борооны эрчимжлээс хамааран үерийн усны хэмжээ, явц өөр өөр байна. Зуны хур борооны үерийн үед гол татмаасаа хальж хөндий усанд автдаг. Зуны их урсцын дараа 9, 10-р сард намрын гачиг үе тохиолдоно.

Хархираа/Гашуун/-ний голын усны тэжээгдлийг тодорхойлох зорилгоор 1979-6-25-нд хийсэн гидрографийн судалгаагаар Тээлийн голын эх Хархираа голын салаа нь Хар толгойн орчим ирээд ширгэж байна. Хархираа/Нарийн ус/-ний голыг булгууд ба мөсний ус тэжээж байжээ.

## ТАЙЛБАР БИЧИГ

Энэ өдрийн хэмжилтээр толгойн барилгын хөндлүүрт  $Q=0,887\text{м}^3/\text{сек}$ . 1 километрийн газар дээр  $Q=0,567\text{ м}^3/\text{сек}$ . Энэ хоёр хэмжилтийн дунд үүссэн халиа нь дунджаар  $Q= 0,320\text{ м}^3/\text{сек}$  зарцуулагатай байв.

Иймд Хархираа/Гашуун/-гийн гол нь газар доорхи усаар найдвартай тэжээгддэг байна. Усны түр харуулын ажиглалтын материал тэнд хийсэн судалгаанаас үзэхэд олон жилийн дундаж зарцууллага  $Q=0,45\text{м}^3/\text{сек}$ . Хувьслын коэффициент  $C_v=0,20$ . Хэм тэгшгүй коэффициент 75% хангамжтай модулийн коэффициент  $K_{75\%}=0,75 \times 0,2 + 1$

$\Phi_{75}$ - 1 эгнээний хангамжийн муруйн харьцангуй харайлт

Дулааны улирлын 75%-ийн хангамжтай дундаж зарцуулга

$$Q_{75} = K_{75} \times Q_d$$

$$K_{75} = - 0,715 \times 0,2 + 1 = 0,886$$

$$Q_{75} = 0,886 \times 0,45 = 0,39\text{ м}^3/\text{сек}$$

4, 5- р сард цас мөсний хайлбарын нөлөөгөөр усны зарцуулга нэмэгддэг боловч дулааны улиралд /IV-XI/ тогтмол  $Q_{75}=0,39\text{ м}^3/\text{сек}$  байна. 1999 онд хийсэн нарийвчилсан судалгаагаар энэ зун Хархираа голоор  $Q=80,0\text{ м}^3/\text{сек}$  зарцуулгатай үер, Тээлийн талаар  $13,5\text{ м}^3/\text{сек}$ .

Эндээс шилжүүлэх коэффициент /K/ болбол

$$\hat{E} = \frac{Q_{\text{max. өгүүр}}}{Q_{\text{max. дэд өсдөг}} = \frac{13,5}{86} = 0,17$$



Зураг 28. Хархираа /Гашуун /ний гол салаалж буй хэсгийн орчимд





Зураг 29. Төмөр бетон гүүрийн чиглэлд урсцыг чиглүүлсэн байдал

#### ГОЛЫН УРСЦЫН ГОРИМ

Хархираа Гашуун/ голын урсцын горимын байдлыг үзүүлэх ажиглалтын харуул нь гүүрийн хөндлүүрээс дээш 42 орчим км-т орших Хархираа сумын төвийн харуул юм.

Тооцооны хөндлүүрт олон жилийн дундаж урсцын нормыг тодорхойлохдоо Хархираа /Нарийн ус/ - Тариалан харуулын олон жилийн ажиглалтын материалыг ашиглан урсцын модулийг тооцож хамаарлын муруй байгуулан шилжүүлэх замаар тооцов.

Ажиглалтын материалаас жилийн дунджуудыг авч эгнээ байгуулан, графо-аналитикийн аргаар тооцож үзэхэд ажиглалтын материалын дундаж нь  $Q=4,48\text{м}^3/\text{с}$  урсацтай байна

Усзүйн тодорхойлолтуудын жил бүр давж гарах магадлал/ $P_m$ /-ыг дараах аргачлалаар тооцов. Үүнд:

$$P_m = ((m - 0.3) / (n + 0.4)) * 100\%$$

Олон жилийн дунджуудыг авч эгнээ байгуулан доорх аргачлал бүхий графо-аналитикийн аргаар тооцно. Үүнд:

$$Q_0' = Q_{50\%} - \sigma \Phi_{50\%}$$

## ТАЙЛБАР БИЧИГ

Биномаль хуваарилалтын параметруудийг ажиглалтын эгнээгээр байгуулсан хуваарилалтын шулуутгасан туршиц муруйгаас авна.

Ингэж тооцож үзэхэд  $Q0' = 4,38$  м<sup>3</sup>/сек урсцын хувьслын коэффициент CV=1,04, хэм тэгш бус коэффициент нь Cs=2.08 буюу Cs=2,0Cv болно.

Хархираа/ Гашуун/-гийн голын олон жилийн дундаж урсцын параметрууд янз бүрийн хангамшлаар (өгөгдсөн хөндлүүрүүдэд)

Хөндлүүр	Урсцын параметрууд							
	Ус хураах талбай (км <sup>2</sup> )	Урсцын хэмжиц (л/с) км <sup>2</sup>	Урсцын норм (м <sup>3</sup> /с)	C <sub>v</sub>	C <sub>s</sub>	Янз бүрийн хамгаалал бүхий урсац (м <sup>3</sup> /с)		
						Жилийн эзлэхүүн (сая.м <sup>3</sup> )		
						75%	90%	95%
Ус зүйн харуул (Тариалан)	738	6,61	4,38	1,04	2.08	3,00	2,30	2,20

### ЖИЛИЙН ДОТОРХИ УРСЦЫН ХУВИАРЛАЛТ

Гол мөрний урсцын жилийн доторхи тархалт голын урсацыг бүрдүүлэх үндсэн тэжээлээсээ шалтгаалж сар улирлаар харилцан адилгүй байх ба ихээхэн хувьсамтгай байдаг.

Голын урсцын горим нь жилийн дотор таван үндсэн үетэй байдаг. Үүнд:

1. 10 дүгээр сарын сүүлчийн арав хоногоос эхлэн мөсний үзэгдэл ажиглагдаж 12 дугаар сарын сүүлч гэхэд хөлдөж мөсөн хучилттай байна. Энэ нь 4 дүгээр сарын сүүлч хүртэл үргэлжилнэ.
2. Гол цэлмэж урсацтай болж эхэлмэгц ус хураах талбай дах цас мөсний хайлбар ус урсаж эхлэнэ. Голын нийт уртад оройцоогоор нэг сарын хугацаатайгаар ажиглагдана.
3. Хаврын шар усны үерийн дараа хавар-зуны гачиг урсацтай байх үе эхлэж, голын эхэн ба дунд хэсэгт 20-30 хоног, адагт 1.5 сар ажиглагдана.
4. Зуны улиралд ус хураах талбайд хур бороо орж эхэлмэгц хур борооны үерийн буюу зуны их устай байх үе ажиглагдана. Энэ нь 9 дүгээр сарын сүүлч хүртэл 2-3 сар ажиглагдана.
5. Үүний дараа урсац маш хурдан багасаж намар-өвлийн гачиг урсацтай үе эхлэж 11 дүгээр сар хүрч мөсний үзэгдэл ажиглагдана.

## ТАЙЛБАР БИЧИГ

Голын урсцын жилийн доторхи хувиарлалтын тооцоог хийхдээ жилийн дундаж урсцын эгнээг их урсацтай жилүүд (33%-иас их), ердийн урсацтай жилүүд (33%-иас бага 66%-иас их), бага урсацтай жилүүд (66%-иас бага) гэж хуваагаад орлуулан тавих (компановка) аргачлалаар үйлдэв.

*Хархираа Гашуун/ голын жилийн доторх урсцын хуваарилалт  
янз бүрийн хангамшлаар*

Сар	%	Янз бүрийн хангамшил		
		75%	90%	95%
		Q (м <sup>3</sup> /с)	Q (м <sup>3</sup> /с)	Q (м <sup>3</sup> /с)
IV	3,65	1.314	1.007	0.963
V	6,12	2.196	1.689	1.615
VI	16,5	5.940	4.554	4.356
VII	26,3	9.468	7.259	6.943
VIII	20,1	7.236	5.547	5.306
IX	11,4	4.104	3.146	3.001
X	5,86	2.110	1.617	1.547
XI	3,60	1.296	0.994	0.950
XII	2,52	0.907	0.695	0.665
I	1,55	0.558	0.428	0.409
II	1,11	0.399	0.306	0.293
III	1,30	0.468	0.359	0.343
Жил	100	3,00	2,30	2,20

### ИХ УРСАЦ

Хархираа Гашуун/ голын аль ч хэсэгт хур борооны үер шар усны үерээс олон дахин их хэмжээтэй ажиглагддаг, учир нь голын усны үндсэн тэжээл хур борооны ус юм. Хаврын шар усны үер 5-р сарын сүүлчээс эхлэн ажиглагдах бөгөөд ихэвчлэн 25-30 хоног үргэлжилдэг. Зуны хур борооны үер нь 7-р сарын эхний хоногт ихэвчлэн эхлэн 8-р сарын сүүлч хүртэл ажиглагддаг. Энэ хугацаандаа 2-3 удаа үер давтагдан ажиглагддаг. Тухайн сав газар нь Монгол орны уруйн үер /дунд зэрэг/ болж өнгөрдөг мужид хамаарагдах бөгөөд богино хугацаанд эрчимтэй орсон борооны улмаас их хурдтай үер бууж ирдэг онцлогтой.

*Хархираа -Тариалан харуулын ажиглалтын материал (их урсац)*

№	он	Ажигласан их урсац (Q м <sup>3</sup> /с)	Буурах дарааллаар Q <sub>max</sub> /буу	$P = \frac{m}{n+1} \cdot 100\%$
1	1972	3.27	615.0	6.3
2	1973	4.90	19.3	12.6

## ТАЙЛБАР БИЧИГ

3	1974	7.78	17.6	18.8
4	1975	6.98	16.3	25.1
5	1976	11.5	16.3	31.4
6	1977	9.70	14.6	37.6
7	1978	6.16	13.4	43.9
8	1979	16.3	11.5	50.2
9	1980	19.3	10.8	56.4
10	1981	13.4	9.70	62.8
11	1982	14.6	7.78	69.0
12	1983	16.3	6.98	75.3
13	1984	17.6	6.16	81.6
14	1985	10.8	4.90	87.6
15	1986	615.0	3.27	94.0
Дундаж		843.7		
		165		

*Хархираа/Гашуун/ голын их урсцын параметруудэд янз бүрийн хангамшлаар*

Хөндлүүр	Урсцын параметрууд								
	Ус хураах талбай км <sup>2</sup>	Их урсцын давхарга м <sup>3</sup> /с.км <sup>2</sup>	Q м <sup>3</sup> /с	C <sub>v</sub>	C <sub>s</sub>	Янз бүрийн хангамшил бүхий их урсац			
						1%	2%	5%	10%
Харуул									
Тариалан	738	0.071	165	1,47	3,0C <sub>v</sub>	730	369	213	135
Тооцоот	1163	0.062	70.8	1.47	3,0C <sub>v</sub>	649	328	271	187

### БАГА УРСАЦ

*Хархираа/Гашуун/ голын жилийн урсцын горимд хоёр удаа бага урсац ажиглагдана. Өвлийн бага урсац буюу урсацгүй болж ёроолдоо хүрж хөлдөнө. Энэ хугацаа нь урд оны 11 дүгээр сарын сүүлчээс дараа оны 4 дүгээр сарын сүүлч хүртэл үргэлжилнэ. Зуны гачиг үе цас мөс хайлж дууссаны дараа зуны хур бороо орж эхлэх хүртэлх хугацаанд ажиглагдана. Энэ хугацаа нь ихэвчлэн 5 дугаар сарын сүүлч 6 дугаар сарын эхээр цөөн хоногт ажиглагдана.*

### ГОЛЫН УРСЦЫН ТҮВШИН

*Хархираа/Гашуун/ голын усны түвшин голын урсцын нэгэн адил хавар цас мөсний хайлбар ус урсах үед огцом нэмэгдэж огцом буурч харин хур бороо орж урсац нэмэгдэх үе хүртэл хамгийн бага хэмжээтэй болдог. Зуны хур борооны үерийн үед хэд дахин их утгаа авч нэмэгддэг. Энэ үед хур борооны эрчимжилтээс шалтгаалж хэмжээ,*

## ТАЙЛБАР БИЧИГ

хугацаа нь янз бүр байдаг. Үүний дараа усны түвшин аажмаар буурч намар-өвлийн хамгийн бага түвшин хүрнэ.

Тухай судалгааны хөндлүүрт тохиох янз бүрийн хангамж бүхий усны түвшинг хөндлүүрийн хөндлөн огтлолд зүсэлт байгуулж Шезийн аргачлалаар  $Q=f(H)$  хамаарлын муруй байгуулж гаргалаа. Үүнд:

$$Q = v F$$

Энд:  $Q$  - үерийн их урсац / м<sup>3</sup>/с /  
 $v$  - үерийн их урсцын хурд / м/сек /  
 $F$  - усны огтлолын талбай / м<sup>2</sup> /

Үерийн урсцын үеийн хурдыг Шези-Манингийн аргачлалаар:

$$v=C (R I)^{1/2}$$

Энд:  $C$  - Шези-ийн итгэлцүүр / Адааршилаас хамаарна /  
 $I$  - Усны түвшний хэвгий  
 $R$  - Гидравлик радиус

Шези-ийн итгэлцүүрийг

$$C=1/n*(R)^{1/6}$$

Адааршлийн итгэлцүүрийг  $n=0.028$  гэж авч үзэн тооцно.

### ГОЛЫН УСНЫ ЭРДЭСЖИЛТ

Хархираа/Гашуун/ голын усны эрдэсжилт бага, гидрокарбонат кальцийн бүлэгт багтах бөгөөд ионы олон жилийн дундаж 65.9-210.1 мг/л хооронд хэлбэлзэнэ. Голын ус цэнгэг учир хүн, малын ундаа, үйлдвэр аж ахуйн хэрэгцээнд бүрэн тохирно. Хархираа/Нарийн ус/ голын усны химийн найрлага нь бетонон эдлэлд идэмхий чанаргүй найрлагатай байдаг.

### ГОЛЫН ЭРГИЙН ТОГТВОРЖИЛТЫН БАЙДАЛ

Голын нийт уртад голдирлын ёроол нь хайрга чулуу бүхий хурдастай, эргийн тогтворжилт сайн. Нутгийн оршин суугчдаас авсан аман судалгаагаар тухайн

## ТАЙЛБАР БИЧИГ

